



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 0/118

Улаанбаатар хот

Өргөдлийн журмаар хайгуулын тусгай
зөвшөөрөл олгох талбайн солбицлыг
нийтэд мэдээлэх, бүртгэх тухай

Монгол улсын Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль"-ийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.15 дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны 106 дугаар тогтоол, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн А/127 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засгийн газрын 2017 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан өргөдлийн журмаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицлыг нийтэд мэдээлж, Кадастрын хэлтсийн мэдээллийн санд бүртгэхийг Кадастрын хэлтэс /Д.Мөнхтамир/-т үүрэг болгосугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /М.Энхжаргалд/-д даалгасугай.

ДАРГА



Б.БААТАРЦОГТ

10 0772



МОНГОЛ УЛСЫН
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/127

Улаанбаатар хот

Хайгуулын тусгай зөвшөөрөл өргөдлийн
журмаар олгох солбицлыг нийтэд
мэдээлэх, бүртгэх тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3, Засгийн газрын 2017 оны 106 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засгийн газрын 2017 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицлыг нийтэд мэдээлэхийг Геологийн бодлогын газрын дарга Д.Ганбатад даалгасугай.

2. Засгийн газрын 2017 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицлыг Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн мэдээллийн санд бүртгэхийг Ашигт малтмал, газрын тосны газар /Б.Баатарцогт/-т үүрэг болгосугай.

3. Хайгуулын тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон ажлыг зохион байгуулахдаа холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг ягштал биелүүлж ил тод, хариуцлагатайгаар ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газар /Б.Баатарцогт/-т үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, Геологийн бодлогын газрын дарга Д.Ганбат нарт тус тус үүрэг болгосугай.





МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оны 3 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 106

Улаанбаатар
хот

Талбайн солбицлыг тогтоон
нийтэд мэдээлэх тухай


Ашигт малтмалын тухай хуулийн 9.1.11-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл өргөдлөөр олгох талбайн солбицлыг хавсралт ёсоор тогтоосугай.

2. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл өргөдлөөр олгох талбайн солбицлыг тухай бүр нийтэд мэдээлж, ашигт малтмалын кадастрын зураг зүйн бүртгэл, мэдээллийн санд бүртгэн тусгай зөвшөөрөл олгох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдоржид үүрэг болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ж.ЭРДЭНЭБАТ



Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд

Ц.ДАШДОРЖ

Байгаль орчин, аялал
жуулчлалын сайд

Д.ОЮУНХОРОЛ

40	1	Өмнөговь	Хүрмэн	103° 38' 45.15" E	42° 18' 29.84" N
41	1	Өмнөговь	Хүрмэн	103° 38' 45.15" E	42° 18' 45.00" N
42	1	Өмнөговь	Хүрмэн	103° 38' 45.15" E	42° 19' 0.16" N
43	1	Өмнөговь	Хүрмэн	103° 39' 0.31" E	42° 19' 0.16" N
44	1	Өмнөговь	Хүрмэн	103° 39' 15.47" E	42° 19' 0.16" N
45	1	Өмнөговь	Хүрмэн	103° 39' 15.47" E	42° 19' 15.32" N

Тайлбар: Энэхүү хавсралтад нийт 1064479 солбицол бүхий 13.66 сая гектар талбай хамаарна.